

МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт истории и
этнологии

МЕЖДУНАРОДНАЯ
АССОЦИАЦИЯ
МОНГОЛОВЕДОВ

РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт восточных
рукописей



КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: КОЛЛЕКЦИИ РУКОПИСЕЙ И АРХИВНЫХ ДОКУМЕНТОВ

IV

**Международная конференция
при поддержке Президента Монголии**



18-19 апреля, 2019. Улан-Батор

Сборник докладов

Санкт-Петербург — Улан-Батор
2021

ННА 63.4
ДAA 930.1
М-694

Ответственный редактор:	Академик С.Чулуун
Научные редакторы:	доктор филол. наук И.В.Кульганек Ph.D Н.Хишигт
Редакторы, составители:	Ph.D Б.Нацагдорж канд. филол. наук. Н.С.Яхонтова

Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов. Сборник докладов IV международной научной конференции. 18—19 апреля 2019 г. Улан-Батор. Россия. СПб.—УБ. 2021 г. —276 с.,

Сборник представляет собой собрание докладов IV международной научной конференции “Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов”, организованной Институтом истории и археологии МАН, Ассоциацией международных монголоведов и Институтом восточных рукописей РАН в г. Улан-Батор, 18—19 апреля 2019 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов. В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN 978-9919-9646-7-2
DOI 10.25882/z7ch-tr43

© Институт истории и этнологии МАН, 2021 г.
© Институт восточных рукописей РАН, 2021 г.
© Международная ассоциация монголоведов, 2021 г.

МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Түүх, угсаатны зүйн
хүрээлэн



ОЛОН УЛСЫН
МОНГОЛ СУДЛАЛЫН
ХОЛБОО



ОРОСЫН ШИНЖЛЭХ
УХААНЫ АКАДЕМИ
Дорно дахины гар
бичмэлийн хүрээлэн



МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

IV

Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор
зохион байгуулсан



Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2019 оны 4 сарын 18-19
Монгол улсын Улаанбаатар хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Санкт-Петербург - Улаанбаатар
2021

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Хариуцлагатай редактор: Академич С.Чулуун

Эрдэм шинжилгээний редактор:

Хэл бичгийн ухааны доктор И.В.Кульганек

Түүхийн ухааны доктор (Ph.D) Н.Хишигт

Редактор, эмхэтгэгчид:

Түүхийн ухааны доктор (Ph.D) Б.Нацагдорж

Хэлшинжлэлийн дэд эрдэмтэн Н.С.Яхонтова

Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга

- IV. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Монгол улс, Улаанбаатар хот. 2019 оны 4 дүгээр сарын 18-19. Санкт-Петербург-Улаанбаатар., 2019 г. 276 тал.

Монгол улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн болон Олон Улсын Монгол судлалын холбооноос 2019 оны 4 дүгээр сарын 18-19-нд Монгол улсын Улаанбаатар хотноо “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 4 дэх удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.

ОХУ, Монгол улсын гар бичмэлийн сан хөмрөг, архивуудад хадгалагдаж байгаа монгол угсаатан ард түмнүүдийн түүх, хэл, соёлын арвин баялаг эх сурвалж нь тус хурлын эх суурь болсон юм. Эмхэтгэлд монгол судлалын түүх, дэлхийн ба Монгол, Оросын шинжлэх ухааны байдал, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, Монголын уламжлалт болон орчин үеийн нийгмийн асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүд багтсан болно.

ISBN 978-9919-9646-7-2

DOI 10.25882/z7ch-tr43

© Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2021

© ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2021.

© Олон улсын Монгол судлалын холбоо, 2021.

MONGOLIAN
ACADEMY OF
SCIENCES
Institute of History
and Ethnology



INTERNATIONAL
ASSOCIATION FOR
MONGOL STUDIES



RUSSIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of Oriental
Manuscripts



CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

IV

**International Conference
Under the Patronage of the President of Mongolia**



April 18-19, 2019. Ulaanbaatar, Mongolia

Proceedings

St. Petersburg — Ulaanbaatar
2021

ННА 63.4
ДAA 930.1
М-694

Managing Editor:	Academician S.Chuluun
Scientific Editors:	Dr.Sc. (Philology) I.V.Kulganek Ph.D (History) N.Khishigt
Editor, compiler:	Ph.D (History) B.Natsagdorj Cand. Sc. (Philology) N.S.Yakhontova

Cultural heritage of the Mongols: manuscripts and archival collections. Papers of the IV International Conference, April 18-19, 2019. Ulaanbaatar, Mongolia. St.Petersburg —Ulaanbaatar 2019, 276 pages.

This is a collection of papers, presented at the Fourth International Conference organized by the Institute of History and Archeology of the Mongolian Academy of Sciences, the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences and the International Association for Mongol Studies which was held in Ulaanbaatar on April 18-19, 2019.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples. The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN 978-9919-9646-7-2
DOI 10.25882/z7ch-tr43

© Institute of History and Ethnology, MAS 2021
© Institute of Oriental Manuscripts, RAS 2021
© International Association for Mongol Studies, 2021

ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ / CONTENT

Өмнөтгөл (С.Чулуун)	9
<i>Г.Ариунтуяа</i>	
Монгол Улсын Үндэсний Төв Архив дахь Ж.Цэвээний хувийн хөмрөг	11
<i>Д.Баярсайхан</i>	
Монголчуудын тухай XIII-XIV зууны Армян сурвалжийн тойм	23
<i>Ts.P.Vanchikova</i>	
Folklore Heritage of the Buryats in the Funds of the COMX and Problems of its Research and Conservation	35
<i>Ж.Гэрэлбадрах</i>	
Монгол Улсын Газар зохион байгуулалт, Геодези, Зурагзүйн газрын архивт буй нутгийн зургийн цуглуулга	43
<i>Л.С.Дампилова</i>	
Шаманские материалы в фонде Т.К.Алексеевой в ЦВРК ИМБТ СО РАН	57
<i>Ж.Долгорсүрэн</i>	
Эрдэмтэн, зохиолч, найруулагч, орчуулагч Э.Оюун: хэвлэгдээгүй гар бичмэл, намтрын баримтууд	65
<i>Г.А.Дыргеева</i>	
Традиционная письменная культура Бурят: социолнгвистический аспект	73
<i>Г.А.Гребенищикова</i>	
Монголия в планах Военного и Морского ведомств России в 1903-1913 годах	84
<i>В.Ю.Жуков, И.В.Кульганек</i>	
«История монголов» О.М.Ковалевского: первое прочтение	98
<i>И.М.Захарова, М.В.Мандрик</i>	
К вопросу о деятельности Советника при Монгольском правительстве П.А.Витте	107
<i>С.Мөнхсайхан</i>	
Уламжлалт монгол хэл зүйн бичгүүдийн хэл шинжлэлийн ач холбогдол хийгээд сурвалж бичгийн үнэ цэнэ	121
<i>Б.Нацагдорж</i>	
Тод үсгийн нэгэн захидлаас <i>Ойрад</i> хэмээх нэрийн тухай тодруулах нь	136

Д.А.Носов

Россыпи документов В.А.Казакевича: отчеты о поездках
по Монголии 1923—1925 гг. 149

К.В.Орлова

Документальное наследие калмыков: письма калмыцких ханов 160

Р.Ю.Почекаев

Суд и процесс в монгольских «Хождениях в ад» 167

Г.Сэр-Од

Монгол Улсын Үндэсний төв архивын сан хөмрөг дэх
Тамга, захирлага, тэмдгийн цуглуулга хөмрөг 176

М.В.Федорова

Монгольские фотоколлекции конца XIX — начала XX вв.
в собрании Российского этнографического музея, как источник
для изучения традиционной культуры монголов 186

Ц.Цэрэндорж

XV-XVIII зууны Солонгос сурвалж дахь Монголын түүхэнд
холбогдох мэдээ баримтаас 204

Д.Энхцэцэг

Монгол – Мингийн харилцаа: захидал бичгийн тухай 219

Ц.Энхчимэг

“Төмөрийн цаазын бичиг”: Монголын эзэнт гүрний түүхийн
чухал сурвалж болох нь 240

Н.С.Яхонтова

Аспиранты из Монголии в Академии наук 250

Сведения об авторах 268

Зохиогчдын танилцуулга 272

Г.Сэр-Од

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВЫН
САН ХӨМРӨГ ДЭХ ТАМГА, ЗАХИРЛАГА, ТЭМДГИЙН
ЦУГЛУУЛГА ХӨМРӨГ**

DOI 10.25882/pjch-xz64

Түлхүүр үг: *Үндэсний төв архив, тамга, тэмдэг, албан бичгийн нүүр тэмдэг*

Тамга судлал нь эртний Грекийн “дардас” гэдэг үгнээс үүсэлтэй. Дэлхийн улс түмнүүдийн тэргүүн бэлгэдэл нь тамга байдаг. Тийм учраас тамга нь тусгаар тогтнолын баталгаа болж, төрийн эрх барих дээд байгууллагаас гаргасан хууль, дүрмийн хүчин төгөлдөр бичиг баримтыг баталгаажуулдаг.

Аливаа төрийн тамга, тэмдэг нь тухайн орныхоо улс төрийн амьдралын хувьсал өөрчлөлт, түүхэн нөхцөл байдлын эрхээр шинэчлэгдэж тамганы хэмжээ, хэлбэр дүрс өөрчлөгдөж ирсэн байна. Улсын эрх барих дээд байгууллага нь Ардын Их Хурал, Ардын Депутатын Их Хурал гэх мэтээр нэрээ өөрчлөх явцад тамганы бичээс, хэлбэр өөрчлөгдөж байжээ. Шинэ тамга, тэмдэг батлагдан эрхэмлэгдэх бүр өмнө хэрэглэж байсан нь хүчингүй болж, Судар бичгийн хүрээлэн, Шинжлэх ухааны хүрээлэн, Улсын архивын газруудад хадгалагдаж иржээ.

Үндэсний төв архивын Түүхийн баримтын архивын сан хөмрөгийн “Тамга, тэмдгийн цуглуулга” (ХМ №169) хэмээх хөмрөгт 1700-1911 он хүртэл хэрэглэж байсан тамга 41, тэмдэг 8, захирлага 5 ширхэг хадгалагдаж байна. Эдгээр тамга, тэмдэг, захирлагууд нь ихэвчлэн амьтны дүр бүхий бариултай бөгөөд металлаар үйлдсэн байна. Тэдгээрээс сонирхуулан дурдвал, Өндөр гэгээн Занабазарын шүншиглэсэн Очирай бат Түшээт хааны тамга¹, Халхын тамгатай 13 хутагтын Егүзэр хутагт², Жалханз хутагт³, Эрдэнэ мэргэн ноён хутагтын шавь нарыг захирах тамга⁴, Халхын 86 хошуудын зарим хошуу

¹ МУУТА, ТБА, Х.М169, Д.1, ХН.23

² МУУТА, ТБА, Х.М169, Д.1, ХН.38

³ МУУТА, ТБА, Х.М169, Д.1, ХН.36

⁴ МУУТА, ТБА, Х.М169, Д.1, ХН.3

захирагчийн тамга⁵; Нийслэл Хүрээн дэх Түшээт хан аймгийн жасааны тэмдэг⁶, Нийслэл Хүрээ ба Маймаа хотын иргэдийн хэргийг шийтгэх захирлага⁷ зэрэг монголчуудын тамга, тэмдгийн уламжлалыг хадгалан үлдсэн биет соёлын үнэт өвүүд хадгалагдаж байна.

Үндэсний төв архивын Түүхийн баримтын архивын “Тамга, тэмдгийн цуглуулга” (ХМ №169) хөмрөгт ороогүй, ямар нэгэн данс бүртгэлд бүртгэгдээгүй, их хэмжээний тамга, тэмдэг, албан бичгийн нүүр тэмдгүүд олон жилийн турш хайрцаг саванд хураагдан хадгалагдаж ирсэн байна.

Архивын ерөнхий газрын даргын 2018 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн “Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй аймаг, хошуу болон албан байгууллагын тамга, тэмдэг, захирлага бүртгэх ажлын хэсэг байгуулах тухай” А/06 тоот тушаалын дагуу тус газрын Мэргэжил, арга зүйн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Н.Оюунсүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг Үндэсний төв архивын Түүхийн баримтын архивт хадгалагдан буй 6000 шахам огт бүртгэл дансгүй тамга, тэмдэг, албан бичгийн нүүр тэмдгүүдийг тоолж, цэвэрлэж, аймаг хошуу болон байгууллагаар нь ялган, дардсыг нь хуулбарлан авч, нэгдсэн бүртгэлд оруулан, хөмрөгийн дансыг богино хугацаанд чанартай бэлтгээд 2018 оны 6 дугаар сарын 8-ны өдөр удирдлагад албан ёсоор танилцуулж, 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Үндэсний төв архивын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын 5 дугаар хурлаар 6 дансыг хэлэлцүүлж, батлуулсан болно. Энэ дансанд шинээр бүртгэгдсэн тамга, тэмдэг, албан бичгийн нүүр тэмдгүүдийг товч өгүүлэхүл:

Нэг. Тамга

Монголчууд төрийн албан хэрэгт алт, мөнгө, хаш чулуун тамга хүндэтгэн хэрэглэж байснаа 1921 оноос болд, гууль, модон тамгыг ихээр хэрэглэж эхэлсэн байна. Улмаар 1924 онд хуралдсан Улсын анхдугаар их хурлаас баталсан Анхдугаар үндсэн хуулийн зургаадугаар бүлэгт: *“...Улсын Их Хурлаас дараалан Засгийн газар, олон яамд, төрийн байгууллагууд тамгыг цөм дөрвөлжин бөгөөд нүүрний дунд хэсэгт соёмбо гэдэг эрхэм үсэг, түүний хоёр этгээдэд уул газрын нэр сэлтийг үйлдүүлэн*

⁵ МУҮТА, ТБА, Х.М169, Д.1-ийн бүртгэлийг үзнэ үү.

⁶ МУҮТА, ТБА, Х.М169, Д.1, ХН.42

⁷ МУҮТА, ТБА, Х.М169, Д.1, ХН.46

гүйцэтгэвэл зохино”⁸ гэж төрийн тамганы үндсэн загварыг тогтоосноор дөрвөлжин хэлбэр бүхий тамга, тэмдгийг хэрэглэх болсон байна.

1924 оны Анхдугаар үндсэн хуулиар “Бүх Монгол улсыг Бүгд Найрамдах Бүрэн Эрхтэй Ард Улс” хэмээж, улсын дээд эрхийг жинхэнэ ардад эдлүүлэн улсын эрхийг Улсын Их Хуралд хадгалуулахаар заасан. Үндсэн хуулиар улсын нэрийг тогтоосон тул төрийн бүх тамга, тэмдгийн бичвэрийг өөрчлөх шаардлагатай болсон. Монгол Улсын төрийн бүх байгууллагын тамга, тэмдэгт Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ) гэсэн нэрийг оруулах болсон тул 1924 оноос хийгдсэн бүх тамга, тэмдэгт өөрчлөлт орж, шинээр үйлдсэн байдаг.

Шашин төрийг хослон барьсан хаант Монгол Улсын үеэс улсын сүлдэнд соёмбо оруулан дөрвөлжин, мөнгөн тамгыг төрийн байгууллагуудад хүндэтгэн хэрэглэж ирсэн байхад Монгол Улсын 30 он (1940 он)-оос дугуй тамга, тэмдгийг хэрэглэж эхэлсэн байна. Энэ нь 1940 онд хуралдсан Улсын VIII их хурлаас баталсан Үндсэн хуулийн дагуу “Улсын сүлд”-ийг өөрчлөн баталсантай холбоотой юм. Тус хуульд дурдахдаа: “БНМАУ-ын сүлд тэмдэг бол дугуй хэлбэртэй, дунд нь Монгол Улсын хангай, тал, говь нутаг дээр нарны зүг уурга барин давхиж яваа морьтой ард байх ба дугуй хөвөөгөөр өвч ногоон дээр хонь, үхэр, тэмээ, ямааны толгойг хоёр талд нь зурж, дугуйн дээд талыг дан алхан хээгээр хүрээлж, дунд нь таван хошуу тэмдэг байна. Өвс ногооны дунд уулзварт улаан лент дээр Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэж бичсэн байна...”⁹ хэмээжээ. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1940 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 63 дугаар тогтоолоор дээрх сүлдийг төрийн тамганд оруулах болсноор тамга нь дугуй хэлбэртэй болсон.

1921 оноос тамга, тэмдгийг болд зэрэг жирийн металл болон модоор хийж байсан ч 1940 оны дунд үеэс буюу 1940 оны БНМАУ-ын хоёрдугаар Үндсэн хууль (Зарим зохиолд “Чойбалсангийн Үндсэн хууль” гэсэн байдаг. Г.С) батлагдан хэрэгжих болсноор тамгыг юугаар үйлдэх, юунд хэрэглэх зэргийг нарийн зааж өгсөн буй. Энэ тухай Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн 34 дүгээр тогтоолд: “...Албан бичигт дарах тамгыг резинээр, лац дарах тамгыг төмөрлөгийн зүйлээр хийсүгэй”¹⁰ хэмээн заажээ.

Тамга, тэмдгийн шинэчлэлтийн нэгэн шинэ үе 1960 оны БНМАУ-ын гуравдугаар Үндсэн хуульд төрийн сүлд тэмдгийг өөрчилсөнтэй

⁸ МУУТА, ТБА, X.11, Д.1, ХН.14, X.17-18

⁹ Д.Өлзийдолгор. Монгол Улсын төрийн тамга (II боть). УБ. 2014. Тал 60.

¹⁰ Мөн тэнд.

холбогдоно. Тухайлбал, 1960 оны Үндсэн хуулийн есдүгээр бүлгийн 90 дүгээр зүйлд: *“БНМАУ-ын төрийн сүлд бол төрийн мөн чанар, улс түмний найрамдлын үзлийг илэрхийлэн тус орны үндэсний болон эдийн засгийн онцлогийг үзүүлсэн байна”* хэмээн тэмдэглээд, *“БНМАУ-ын төрийн сүлд бол тариан түрүүгээр хөвөөлсөн дугуй хэлбэртэй байна. Сүлдний төвд БНМАУ-ын говь, хангай, тал хосолсон нутгаар мандах коммунизмын наран өөд яваа морь унасан хөдөлмөрчин хүн зурсан байна. Сүлдний магнайд тариан түрүүний хоёр үзүүрийн хооронд дундаа алтан соёмбо үсэг бүхий таван хошуу байна”*¹¹ гэж заагаад, шинэ сүлдний хэлбэрийг төрийн байгууллагуудын бүх тамга, тэмдгүүдэд оруулж шинэчилсэн байдаг.

Шинээр бүртгэсэн тамганы хөмрөгийн данс дотор Ардын засгийн эхэн үеийн 7 ширхэг тамга, БНМАУ-ын үеийн 232 ширхэг тамга байна. Жишээ нь, тус тамганы бүртгэлд Монгол Ардын Засгийн хэргийг бүгд захиран шийтгэх газрын тамга, Монгол Ардын Засгийн газрын Дотоод хэргийн яамны тамга, Монгол Ардын Засгийн газрын төлөөний бүрэн эрх барих түшмэлийн тамга, Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнгийн эрхэлсэн сайдын тамга, Тамсагбулаг зэрэг газар Сэргийлэх цэргийг захирах сайдын тамга зэрэг түүхэн ховор тамгануудаас гадна 1921 онд үйлдэгдсэн *“Сурган боловсруулах цэргийн хэргийг шийтгэх ерөнхий түшмэлийн захирлага”* хэмээх 7×7 хэмжээтэй, модон, 1 ширхэг захирлага байна.



Монгол Ардын Засгийн хэргийг бүгд захиран шийтгэх газрын тамга.

Хэлбэр: дөрвөлжин
Төлөв: хус модон
Суурийн хэмжээ: 7×7 см
Өндөр: 2.5 см

¹¹ Д.Өлзийдолгор. Монгол Улсын төрийн тамга (II боть). УБ. 2014. Тал 63.



**Судар бичгийн
хүрээлэнгийн эрхэлсэн
сайдын тамга.**

Хэлбэр: дөрвөлжин

Төлөв: хус модон

Суурийн хэмжээ: 7×7 см

Өндөр: 7 см

1921 онд Номын хүрээлэн буюу Судар бичгийн хүрээлэн анх байгуулагдахад дээрх хус модон тамгыг хэрэглэж байсан ба 1922 оноос АЗГ-аастус хүрээлэнгийн “...модон тамгыг халж, бариул хэмжээг одоогийн үйлдэж буй олон яамны тамганы адил болгон мөнгөөр цутгаж олгуулахаар тогтов”¹² хэмээнээр хус модон тамганахаа оронд металл тамга хэрэглэх болсон юм.



**Сурган боловсруулах
цэргийн хэргийг
шийтгэх ерөнхий
түшмэлийн захирлага**

Олноо өргөгдсөний

11 дүгээр он (1921 он)

Ёслолыг хавсарсан

Дотоод яамнаа үйлдэв.

Хэлбэр: дөрвөлжин

Төлөв: хус модон

Хэмжээ: 7×7 см

Өндөр: 5 см

Жич: Монголчуудын олон зууны турш уламжлан хэрэглэж, хадгалсаар ирсэн тамганы соёлын салшгүй хэсэг бол захирлага юм. Түүх сөхөн үзвэл, тэмдэг захирлагын үүрэг нэмэгдэхийн хэрээр тамга

¹² МУУТА, ТБА, Х-1, Д-1, ХН-76, Х.359-360

бий болсон бөгөөд тамга нь сүр хүч нэмэгдсэнээр захирамжийн үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн итгэмжлэл бүхий тэмдэг хэрэглэх болжээ.

Хоёр. Тэмдэг

Түүхэн сурвалжаас үзвэл, аливаа төрийн албанд эрхэмжлэгдсэн тэмдэг нь анх үүссэн цаг хугацаа нь тамганаасаа эрт бөгөөд тамгыг орлох бүрэн эрх сүр бүхий болохын сацуу тухайн орныхоо улс төрийн амьдралын хувьсал өөрчлөлт, түүхэн жамын эрхээр шинэчлэгдсээр иржээ.

Шинээр ангилан бүртгэсэн бүртгэлд хаант Монгол Улсын үеийн 6 ширхэг тэмдэг, Ардын засгийн эхэн үеийн 41 ширхэг тэмдэг, БНМАУ-ын үеийн 2700-аад тэмдгээс 1924-1931 он хүртэлх тэмдэг 100 шахам бүртгэгдсэн ба шинээр 13 аймаг байгуулагдсан 1931 оноос хойших тэмдэг 2600-аад ширхэг байна. Тэдгээртэмдэгний дансанд нийт 2767 тэмдэг бүртгэгдсэн нь хэмжээний хувьд их тул зохих журмын дагуу 4 боть болгосон. Үүнд:

1 дүгээр боть буюу БНМАУ-ын УБХ, СнЗ, төрийн яамд, Улаанбаатар хот болон төрийн албан газруудад хамаарах 381 тэмдгийн дотор Монгол Улсын Бага хурлын тэргүүлэгчдийн газрын тэмдэг, Монгол Улсын Бага хурлын газрын тэмдэг, Ардын Засгийн газрын тэмдэг, Ардын Засгийн газрын төлөөний түшмэлүүдийн тэмдгүүд, Ардын Засгийн газраас аймгуудад суух түшмэлийн тэмдгүүд, Нийслэл Хүрээний Ерөнхий шийтгэх яамны тэмдэг, Хүрээний баруун ба зүүн гаалийн хорооны тэмдэг, Нийслэл Хүрээний өртөөдийг захирагчийн тэмдэг, Амгаланбаатар хотын Цагдан сэргийлэх хэлтсийн тэмдэг, Шашны хэрэг эрхлэх газрын тэмдэг, Бүх цэргийн зөвлөлийн тэмдэг, 1921-1931 оны үеийн цэрэг, армийн үйл ажиллагаанд холбогдох түүхэн ховор тэмдгүүд бүртгэгдсэн болно.

2 дугаар боть буюу БНМАУ-ын Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Дорноговь, Дундговь аймгуудын захиргаа ба албан байгууллагуудад хэрэглэж байсан тэмдгүүдийн дотор аймгуудын ба сумдын захиргаа, шүүх ба прокурор хийгээд бусад байгууллагуудад тодорхой цаг хугацаанд хэрэглэж байсан тэмдгүүд голчлон бүртгэгдсэн болно. Тэдгээрээс он цагийн хувьд 1920-иод оны дунд үед холбогдох “Эрээнцав дахь Гаалийн хорооны тэмдэг” хэмээх түүхэн ховор, 6×6 см хэмжээтэй, дөрвөлжин, модон тэмдэг бүртгэгдсэн байна.


3 дугаар боть буюу БНМАУ-ын Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв аймгуудын захиргаа ба албан байгууллагуудад

хэрэглэж байсан тэмдгүүдийн дотор бүртгэгдсэн түүхэн ховор тэмдгээс дурдвал: Улиастайн сайдын яамны тэмдэг, Улиастай хотын захиргааны газрын тэмдэг, Алтанбулаг хот дахь захиргааны газрын тэмдэг, Алтанбулаг хотноо суух Гаалийн хорооны тэмдэг, Ерөө голын Модны ангийн тэмдэг, Сангийн Борнуур дахь тариалангийн тэмдэг гэх мэт дээрх аймгуудын түүхэн хөгжилд холбогдох ховор тэмдгүүд орсон байна.

4 дүгээр боть буюу БНМАУ-ын Увс-Дөрвөд, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгуудын захиргаа ба албан байгууллагуудад хэрэглэж байсан 551 ширхэг тэмдэг дотор дээрх аймгуудын ба сумдын захиргаа, шүүх ба прокурор хийгээд бусад байгууллагуудад тодорхой цаг хугацаанд хэрэглэж байсан тэмдгүүдийг бүртгэжээ.

Жишээ нь, энэ бүртгэлийн түүхэн ховор тэмдгээс дурдвал: монгол бичиг болон латин үсгээр хавсран бичсэн Дөрвөд аймгийн Давст-Уул сумын захиргааны тэмдэг, Ховдод сууж мал эмчлэх салбар хорооны тэмдэг, Ховд дахь Сангийн тариаланг эрхлэх газрын тэмдэг, Хэнтийн замын төлөөлөгчийн тэмдэг, Дэлүүн дэх мал эмнэлгийн тасагт үзэв хэмээх тамга, тэмдгийн түүхэн хөгжилд холбогдох ховор тэмдгүүд байна.

Тэмдгийн цуглуулгын дээжээс:



Сангийн явдын яамны Татвар хураах тэмдэг

15 дугаар онд
Дотоод яамнаа үйлдэв
(1925).

Хэлбэр: дөрвөлжин
Төлөв: хус модон
Хэмжээ: 5×5 см
Бариул. 30 см
Өндөр: 6 см



**Хүрээний баруун
Гаалийн**

хорооны тэмдэг

Хэлбэр: дөрвөлжин гонзгой

Төлөв: хус модон

Хэмжээ: 5×7 см

Өндөр: 6 см



**Ардын Засгийн газраас
Хөвсгөл нуурын Урианхайд
түр суугаа төлөөний
түшмэлийн тэмдэг**

15 дугаар онд

Дотоод яамнаа үйлдэв
(1925 он).

Хэлбэр: дөрвөлжин

Төлөв: хус модон

Хэмжээ: 5×5 см

Өндөр: 5 см

Жич: Ардын засгийн бодлого, үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах нь шинэ засгийн чухал зорилтуудын нэг байв. Иймээс ардын хувьсгалын эхний жилүүдэд орон нутагт ажиллах Засгийн газрын төлөөлөгчид онцгой үүрэг гүйцэтгэж байсан. Тиймээс ч Ардын засгаас төлөөний түшмэлүүдэд Засгийн газрын зорилго, үйл ажиллагааг олон түмэнд зөвөөр тайлбарлах, таниулах үүрэг даалгавар өгч, улс орны онц чухал ач холбогдол бүхий хошуу тамга ба шавь отгуудад суулгасан. Иймээс Ардын засгийн бодлогыг олон түмний дунд явуулах их үйлст төрийг төлөөлөн ажиллаж байсан “**Ардын засгийн төлөөний түшмэл**”-ийн ажил хэргийг баталгаажуулах үүднээс тэмдэг шийтгэн

олгожээ. Үндэсний төв архивын шинээр бүртгэгдсэн “Тамга, тэмдэг, албан бичгийн нүүр тэмдгийн цуглуулга”-д 18 ширхэг Ардын засгийн төлөөний түшмэлийн тэмдэг буй.

Гурав. Албан бичгийн нүүр тэмдэг

Албан бичгийн нүүр тэмдгүүд нь 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиудад төрийн сүлд тэмдгийг өөрчилсөнтэй холбогдуулан төрийн тамга, тэмдгийг шинэчлэн тогтоох явцад өөрчлөгдөж байснаас гадна тухайн байгууллагын эрх хэмжээ, нэрийн өөрчлөлтийг баримталж байсан байна. Тухайлбал, монгол бичиг, латин үсэг, кирил үсгийн хэрэглээг дагалдан тамганы бичвэрт тухайн үед хэрэглэж байсан үсгийн бичвэр давамгайлсан байх ба төрийн хэмжээний томоохон байгууллагуудаас бусад албан газрууд сүлд тэмдэггүй албан бичгийн нүүр тэмдгийг хэрэглэж байсан байна.

Ийнхүү үндсэн хуулиуд болон төрийн засаглалын хэлбэрийн өөрчлөлтийг дагалдан тамга, тэмдгийн хэмжээ, хэлбэр дүрс өөрчлөгдөх явцад албан бичгийн нүүр тэмдэг ч мөн адил хэлбэр хэмжээ, дардас зэрэг нь өөрчлөгдөж ирсэн байна.

Албан бичгийн нүүр тэмдгийн 355 хадгаламжийн нэгж дотор Богд хан уулын аймгийн яам, БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн газар, БНМАУ-ын Сангийн явдлын яам, БНМАУ-ын Олзлогдсон цэргийн хэргийг эрхлэх газрын прокурор, Амгаланбаатар хотын захиргаа, Улаанбаатар хотын захирах яам, Улаанбаатар хотын Захиргааны хэргийг эрхлэх газруудад хэрэглэж байсан түүхэн ховор албан бичгийн нүүр тэмдгүүд байх төдийгүй “БНМАУ. Өмнөговь аймгийн Гар үйлдвэрийн төлөөлөгчийн газар” хэмээх бичээс бүхий 4×15 см хэмжээтэй, гонзгой, хэвтэж буй арслангийн дүр бүхий бариултай, байгалийн чулуугаар хийсэн маш сонирхолтой албан бичгийн ховор нүүр тэмдэг байгааг онцлон дурдаж болох юм.

Албан бичгийн нүүр тэмдгийн цуглуулганы дээжээс



**Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ардыг гэгээрүүлэх яам**

Хэлбэр: дөрвөлжин гонзгой
Төлөв: хус модон
Хэмжээ: 5×18 см
Өндөр: 2.5 см



**БНМАУ
Өмнөговь аймгийн
Гар үйлдвэрийн
төлөөлөгчийн газар**

Хэлбэр: гонзгой
Төлөв: баргилт чулуун
Хэмжээ: 4×18 см
Өндөр: 4 см

Жич: Монголчууд төрийн
тамгыг үйлдэхдээ зарим нэгэн
тогтсон уламжлалтай байв.

Тухайлбал, тамганы иш бариулыг хийхдээ онцгой анхаарч XX зуунаас өмнө бол сүр хүчит амьтны дүрс, үндэсний хээ угалз, бат тогтвортойн бэлгэдэл болох дүрслэлээр хийдэг байв. Жишээлбэл, барс зэрэг амьтны дүрс бүхий иштэй тамгыг монголчууд тэр дундаа хаад ноёд, төрийн томоохон байгууллагууд олон зууны турш эрхэмлэн хэрэглэсээр ирсэн түүхтэй.

Хаант Монгол Улсын үед амьтны бэлгэдэлт дүрслэл бүхий тамганы оронд “хүслийг хангагч чандмань эрдэнийн дүрслэл” бүхий иштэй тамгыг хэрэглэж байсан байдаг. 1924 оноос элдэв хээ чимэглэлгүй энгийн цулгуй мод болон металл бариулыг тамгандаа хэрэглэж ирсэн байна.

Эцэст нь тэмдэглэхэд энэхүү шинээр бүртгэгдсэн тамга, тэмдэг, албан бичгийн нүүр тэмдгүүд нь Монгол Улсын төрийн байгууллагуудын түүхийн судалгаа хийгээд “Тамга судлал”-д онц ач холбогдолтой эрдэм шинжилгээний эх хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй юм.